



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-10-75, Факс: 32-70-16
E-mail: fiscalcouncil@parliament.mn

2026.05.06 № 34

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төсвийн тогтвортой байдлын хуулийн 16¹ дугаар зүйлийн 16.5.2-т заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хүргүүлж байна.

Энэ хүрээнд “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний холбогдох материалуудыг судалж, төлөвлөлтийн бодлого, төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээ, төлөвлөсөн санхүүжилт болон бодлогын уялдаа холбоо, үр дүнд шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг боловсрууллаа.

Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлтийн уялдаа, бодлогын чиглэлд нийцсэн эсэх, төсөл, арга хэмжээний сонголт, санхүүжилт зэрэг олон талт хүчин зүйлсээс хамаарч байгааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл онцолж хөгжлийн төлөвлөллөгөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөмжүүдийг дүгнэлтэд тусгасан болно.

Хавсралт ³³ хуудастай

Хүндэтгэсэн,

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Ж.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 05 дугаар сарын 06

АГУУЛГА

НЭГ. Удиртгал.....	3
ХОЁР. Макро эдийн засгийн өнөөгийн төлөв байдал, эрсдэл.....	4
ГУРАВ. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хоорондын уялдаа, хамаарал, залгамж чанар	5
ДӨРӨВ. Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл ба жилийн төлөвлөгөөний уялдаа	10
ТАВ. Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүн ба хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт хоорондын уялдаа, нийцэл.....	13
ЗУРГАА. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний, хөрөнгө оруулалт санхүүжилт, түүний эх үүсвэр.....	15
ДОЛОО. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан томоохон төслүүдийн талаар.....	22
НАЙМ. Дүгнэлт, зөвлөмж.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн салбарууд /2016-2025 он/	4
Хүснэгт 2. Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө ба урт, дунд хугацааны бодлогын уялдаа	6
Хүснэгт 3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх	7
Хүснэгт 4. Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх	8
Хүснэгт 5. Бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	9
Хүснэгт 6. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл	10
Хүснэгт 7. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, үндэсний үр дүн	11
Хүснэгт 8. Бодлогын чиглэл болон төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилт /сая төгрөг/.....	16
<i>Хүснэгт 9. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, эх үүсвэрийн төрлөөр</i>	<i>18</i>
Хүснэгт 10. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагч буюу байгууллагуудаар, санхүүжилт /сая төгрөг/.....	20

НЭГ. УДИРТГАЛ

Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах” тухай УИХ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтын дагуу уг дүгнэлтийг гаргалаа. Дүгнэлт гаргахдаа хөгжлийн төлөвлөгөөний төсөл нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаж буй байдлыг болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.13, 4.1.15 6.10.1, 6.10.2 дахь заалтад, хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур хангасан эсэхийг тус хуулийн 5.1, 5.2 дахь заалтад тусгасан шаардлагад нийцсэн эсэхийг шинжилж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

ТТБЗ дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зэрэг хуулиуд, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг үндэслэл болгосон.

Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, “Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” (Хавсралт 1), “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө” (Хавсралт 2), “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” (Хавсралт 3) гэсэн баримт бичгүүдийг судалж, макро эдийн засгийн 2027 оны төлөв байдал, тулгарч болзошгүй эрсдэл, бодлогын уялдаа, стратегийн болон хуулийн нийцэл, бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө, хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, төсөв хоорондын уялдааг SMART үнэлгээ, нийцлийн шинжилгээний аргачлалыг ашиглан шинжилсэн болно.

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бодлогын чиглэл, хоорондын уялдаа холбоо, төлөвлөгөөний иж бүрдэл, зорилгод чиглэсэн байдал, нөхцөл байдлын шинжилгээ зэргийн хувьд баримт бичгийн түвшинд ахиц дэвшил гарч байгааг дурдаж байна. Гэхдээ нөхцөл байдалтай уялдаатай байдал, залгамж чанар, үр дүнд чиглэсэн байдал дутмаг хэвээр байна.

ХОЁР. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРСДЭЛ

Зарчим: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.8-т “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлохдоо нөөцийн хязгаарлалт болон эрсдэлийг харгалзан үзэж, тогтоосон хугацаанд биелүүлэх боломжтой, бодит, хэмжигдэхүйц зорилго, зорилт дэвшүүлэхийг;” (УИХ, 2020)

Макро эдийн засгийн өсөлтийн хангагдах нөхцөл бүрдсэн эсэхэд анхаарах шаардлагатай. Засгийн газраас өргөн барьсан төсөлд 2025 оны эдийн засгийн урьдчилсан гүйцэтгэлийн шалтгааныг нарийвчлан тодорхойлсны дагуу эдийн засаг ХАА-н салбарын уналтын дараах өсөлтөөс ихээхэн хамаарсныг дурдсан. ХАА-н салбар 2024 онд эдийн засгийн нийт өсөлтийг 3.6 нэгж хувиар хойш татаж, ДНБ-ий бодит өсөлт 4.9 хувь байсан бол 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 89.9 их наяд төгрөгт хүрч, 6.8 хувиар өссөн өсөлтийн 2.9 хувийг бүрдүүлсэн. Энэ нь тухайн өсөлт 2026 онд үргэлжлэх магадлал багатай гэдгийг харуулах хүчин зүйл. Гэтэл 2026 онд буюу хөгжлийн төлөвлөлтийн суурь оны эдийн засгийн өсөлтөд өмнөх жилүүдийн өсөлттэй гол салбаруудын үргэлжилсэн өсөлт, Засгийн газраас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нөлөөлөл, дэд бүтцийн томоохон төслүүдээс хамаарах барилгын салбарын өсөлт нөлөөлнө гэж үзсэн. Харин “Бөөний болон жижиглэн худалдааны салбарын 2025 онд агшилттай байсан суурийн нөлөө, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17), аялал жуулчлалын салбарын өсөлт болон эдийн засгийн дотоод эрэлт нэмэгдэх хүлээлттэй байгаагаас үүдэн худалдаа, үйлчилгээний салбарууд эдийн засгийн өсөлтөд 3.0 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байна.” (МУЗГ, 2026) гэсэн нь эдийн засгийн голлох нөлөөлөл болохоор хүлээгдэж байна. Үүнээс үйлчилгээний салбар нь хэдийгээр эдийн засагт томоохон байр суурь эзэлж байгаа боловч эдийн засгийн өсөлтийн 50+ хувийг бүрдүүлэх боломжтой эсэхэд анхаарах нь зүйтэй юм. Доорх хүснэгтэд сүүлийн 10 жил Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тодорхойлсон гол салбаруудыг харуулав.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн салбарууд /2016-2025 он/

Эдийн засгийн салбар	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Бүгд	1.49	5.64	7.75	5.6	-4.56	1.64	5.03	7.42	5.12	6.84
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.76	-0.04	0.9	0.72	0.79	-0.83	1.68	-1.33	-3.64	2.86
Уул уурхай, олборлолт	-0.29	-0.68	0.86	-0.25	-1.44	0.12	-2.08	2.58	1.36	1.41
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.21	1.94	1.98	1.04	-1.06	1.31	1.36	0.83	1.83	0.04
Өндөр өсөлттэй салбарын эдийн засгийн өсөлтөд эзлэх хувь	51%	34%	26%	19%	17%	80%	33%	35%	36%	42%

Эх сурвалж: (ҮСХ, 2026)

Эндээс харвал худалдаа үйлчилгээний салбар нь эдийн засгийн өсөлтийн голлох нөлөөллийг бий болгох үндэслэлийг баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх дотоод, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзэх шаардлагатай байна. Эдийн засгийн өсөлтөөс гадна макро эдийн засгийн хувьд инфляц нь анхаарах гол хүчин зүйл болоод байгааг хөгжлийн бодлого төлөвлөлтөд анхаарах шаардлагатай байна. 2025 онд инфляц оны дунджаар 8.6 хувь, оны эцэст 7.5 хувь гарсан. 2026 оны эхний хагаст хүнсний инфляц өндөр хэвээр хадгалагдах, шатахуун, бараа үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байна. Үүн дээр эрчим хүчний үнийн өөрчлөлт, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан импортыг өдөөх төслүүд, 2027-2028 оны төсвийн бодлогын нөлөөлөл орж хөгжлийн бодлогын зорилтуудад сөргөөр нөлөөлөх боломжтойг анхаарах шаардлагатай. Нэг салбараас ихээхэн хамааралтай, тухай салбар нь эрсдэлтэй мөчлөгтэй байдаг тул эрдсийн бүтээгдэхүүний үнэ, геополитикийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт зэргийг харгалзан үзэж нөлөөллийг тооцох шаардлагатай.

Хөгжлийн төсөл хөтөлбөрийн, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллийг баталгаажуулах шаардлагатай. Хөгжлийн төлөвлөлтийн баримтад “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Атар-4” зэрэг хөтөлбөр, аяны хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын өсөлтийг дэмжих нөлөөтэй байна. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд 2022-2025 онд нийт 1,261 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд 2025 онд эргэлтийн хөрөнгийн 23.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын 15.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгосон ба 2026 онд 29.6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгохоор төлөвлөсөн байна.” “Газар тариалангийн талбайг нэмэгдүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг өсгөх зорилт дэвшүүлээд буй “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна.” Барилгын салбарт томоохон бүтээн байгуулалтын төслүүд салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна.” гэсэн тойм байдлаар эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх үндэслэлүүдийг тодорхойлсон. Гэхдээ өмнөх жилүүдийн өсөлтөд хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн нөлөө хэр байсан болон эдгээр төслүүдийн хэрэгжилт 2026 онд нөлөөлөх баталгаа байгаа эсэхийг харгалзах шаардлагатай.

ГУРАВ.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХООРОНДЫН УЯЛДАА, ХАМААРАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР

Зарчим: Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.4-т “тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхдээ бодлогын тогтвортой байдлыг хадгалж, өмнө батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн, үнэлгээнд үндэслэхийг” 6.10.1-т “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх” гэж заасныг энэ хэсэгт удирдлага болголоо.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд нийцүүлэн урт, дунд, богино хугацааны нийгэм, эдийн засгийн зорилтуудыг тодорхойлж, баримт бичгүүдийн уялдааг хангах, төсөв, санхүүгийн нөөцийг хуваарилах, хэрэгжилтийг хянах, үнэлэх цогц үйл ажиллагаа юм. Ялангуяа 2027 оны хөгжлийн төлөвлөгөө нь *нэгдүгээрт*, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, *хоёрдугаарт*, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан “Монгол

Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ыг хэрэгжүүлэх суурь он болохын хувьд, *гуравдугаарт*, Уул уурхайгаас хамааралтай эдийн засгаас бүсчилсэн, төрөлжсөн, дэд бүтцийн хангамж зохих түвшинд хүрсэн, тогтвортой эдийн засагт шилжих нэн чухал үе шат болж байгаа нь онцлог юм.

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрийн “бодлогын үндэслэл”-ийг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсруулсан байна.

Хөгжлийн бодлогын уялдааг сайжирсан боловч хуулийн зарчим, шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж буйг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө ба урт, дунд хугацааны бодлогын уялдаа

№	Бодлогын түвшин	Бодлогын баримт бичиг	Уялдаа	Тайлбар
1	Урт хугацааны (2020-2050)	“Алсын хараа-2050”-ын I шат буюу 2030 он хүртэлх үе	Зарчмын хувьд уялдсан	Хөгжлийн 9 зорилгыг хэрэгжүүлэх арга төсөл, хөтөлбөрүүд жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой хэмжээгээр туссан боловч суурь үзүүлэлт, үе шат, шалгуур нь тодорхойгүй байна.
2	Урт хугацааны (2024-2050)	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал I үе шат буюу 2024-2030 он	Хэсэгчлэн уялдсан	Хот, хөдөөгийн болон бүсүүд хоорондын хөгжлийн ялгаатай байдлыг бууруулах зорилгоор бүс нутгуудын төрөлжилтийг дэмжих арга хэмжээнүүд тусгагдсан ч хөрөнгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх магадлалтай.
3	Урт хугацааны (2016-2030)	Тогтвортой хөгжлийн зорилтууд	Зорилгын хувьд уялдсан	Хүний хөгжил, ядуурал, боловсрол, эрүүл мэнд, жендер, дэд бүтэц зэрэг зорилгууд тусгагдсан ч ТХЗ-ын үзүүлэлтүүдийг шууд ашиглаагүй байна.
4	Дунд хугацааны (2021-2031)	Шинэ сэргэлтийн бодлого	Сайн уялдсан	Шинэ сэргэлтийн бодлогын 6 чиглэл (эрчим хүч, төрийн бүтээмж, аж үйлдвэржилт гэх мэт)-ийг хэрэгжүүлэх зорилтууд тусгагдсан байна.
5	Дунд хугацааны (2026-2030)	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Сайн нийцсэн	Төлөвлөгөө 5 жилийн үндсэн чиглэлийн зорилтот шалгуур үзүүлэлтүүдийн 2027 оны түвшнийг хангах хүрээнд боловсруулсан байна.
6	Дунд хугацааны (2024-2028)	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Сайн нийцсэн	Төлөвлөгөөг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ДХТХМ-тэй уялдуулан боловсруулж, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг ТХЗ-ын үзүүлэлттэй нийцүүлсэн нь Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг олон улсын түвшинд үнэлэх боломж олгож байна.
7		Засгийн газраас	Сайн уялдсан	Энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн бизнесийн орон зайг тэлэх,

	Богино хугацааны (2026-2028)	дэвшүүлсэн “Чөлөөлье” санаачилга		зөвшөөрлийн тогтолцоог шинэчлэх, ногоон эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийг дэмжих, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд ил тод, нээлттэй хяналт тогтоох зорилтууд тусгагдсан байна.
--	------------------------------	----------------------------------	--	---

Эх сурвалж: Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд үндэслэн ТТБЗ-өөс өгсөн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой зорилгын хувьд уялдаатай боловч гүйцэтгэлийн түвшинд (шалгуур үзүүлэлт, мониторинг) уялдаа нь бүрэн хангагдаагүй хэвээр байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хуулиудад тусгагдсан шаардлагуудыг Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө хангаж байгаа эсэхийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх

№	Хуулийн шаардлага	2027 оны төлөвлөгөөний байдал	Үнэлгээ
1	Бодлогын зорилго, зорилт тодорхой байх	Төлөвлөгөөний төсөлд бодлогын тэргүүлэх 4 үндсэн чиглэл (эдийн засаг, хүний хөгжил, бүсчилсэн хөгжил, засаглал) ба дэд зорилтууд тодорхой тусгагдаж, салбар хоорондын уялдааг сайжруулахад анхаарсан байна. Харин энэ нь бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжих нь төсвийн хуультай хэрхэн уялдах, хувийн хэвшлийн оролцоо хэр байх болон хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс хамаарна.	Сайн
2	Үр дүнд суурилан төлөвлөсөн байх	Төлөвлөгөө нь үр дүнг хэмжих, салбар хоорондын уялдааг хангах замаар үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчмыг ерөнхийдөө хангаж байгаа ч хэрэгжилтийн явцад төсөв болон тайлагналтай уялдуулах шаардлагатай. Бодлогын баримт бичгийн хавсралт 2-т зарим шалгуур үзүүлэлт нь тодорхой, гэхдээ SMART биш үзүүлэлт олон байна.	Дунд
3	Төрийн байгууллагын оролцоо, хариуцлага тодорхой байх	Төлөвлөгөөний төсөлд төрийн байгууллагын оролцоо, хариуцлагыг тодорхой болгох шаардлагыг өмнөх жилүүдээс илүү өндөр түвшинд тусгахыг зорьсон ч хүнд суртлыг бууруулах, хувийн хэвшлийг дэмжих, төсөл хэрэгжүүлэх шатанд төрийн байгууллагуудын оролцоо нь сахилга баттай, нээлттэй байх шаардлага хэвээр байгаа нь ЭЗХЯ-ны танилцуулгаас харагдаж байна. Хариуцагч байгууллагуудыг заасан ч хяналт шинжилгээ, хариуцлагын механизм тодорхойгүй.	Дунд
4	Төлөвлөгөөний уялдаа, давхардалгүй байдал	Өмнөх жилүүдийн бодлогын хэрэгжилтийн алдаа дутагдлыг (давхардал, уялдаагүй байдал) засаж, баримт бичгүүдийн давхцалыг арилгах зорилтыг боломжийн түвшинд хангаж байна. Бодлогын 3 баримт бичиг (хавсралтууд)-ийн хоорондын уялдаа бүрэн хангагдаагүй байна.	Дунд
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний тогтолцоо тусгагдсан байх	Тогтолцооны хувьд тусгагдсан ч НҮБХХ-ийн зөвлөмжөөс үзэхэд ХШҮ-ний тогтолцоонд цахим шилжилтийг бүрэн нэвтрүүлж, мэдээллийн нэгдсэн санг илүү нээлттэй болгох, хэрэгжилтийн явцад гарах зөрчлийг арилгах, хариуцлагын тогтолцоог илүү чангатгах шаардлагатай төдийгүй үзүүлэлтүүдийн үнэлгээ, тайлагналын хугацаа, аргачлалыг нарийвчлан заагаагүй байна.	Хангалт-гүй

Эх сурвалж: Хууль тогтоомжид үндэслэн ТТБЗ-ийн хийсэн үнэлгээ

Жилийн хөгжлийн төлөвлөгөө нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан бодлого, төлөвлөлтийн бүтэц, шатлал, логик уялдааг хангаж байгаа боловч

хяналт шинжилгээ, гүйцэтгэлийн хариуцлага, шалгуур үзүүлэлтүүд SMART байх шаардлагыг дутуу хангасан байна.

Хүснэгт 4. Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэх

№	Хуулийн шаардлага	2027 оны төлөвлөгөөний байдал	Үнэлгээ
1	Төсөв нь хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байх	Хөгжлийн төлөвлөгөө нь төсөвтэй уялдсан байх шаардлагыг хуулийн хүрээнд хангаж байгаа ч зарим төсөл, хөтөлбөрийн зардал, санхүүжилт, зорилтот үр дүн нь тодорхойгүй байна.	Хэсэгчлэн хангасан
2	Хөрөнгө оруулалтын зардлын үндэслэл тодорхой байх	Хөрөнгө оруулалтын зардлын үндэслэлийг тодорхой болгох, төсвийн сахилга батыг сайжруулах шаардлагыг сайжруулж, ил тод, үр дүнд суурилсан хэлбэр рүү шилжих оролдлого хийж байгаа ч судалгаа, төлөвлөлтийн шатанд анхаарах асуудлууд байсаар байгаа нь томоохон төслүүдийн зардал, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөж, үр ашиг тусгагдаагүйгээс харагдаж байна. Мөн хэрэгжилтийн түвшинд (ТЭЗҮ-ийн чанар, төсөвт өртөг, хугацаа) хөрөнгө оруулалтын төслийн сахилга батыг илүү чангатгах шаардлагатай байна.	Дунд
3	Төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдалтай уялдуулах	Төлөвлөгөө нь цаасан дээр төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлын дүрмүүдийг хангаж байгаа боловч макро эдийн засгийн эрсдэлтэй орчинд хэрэгжихээр төлөвлөгдсөн нь төсвийн алдагдал, өрийн дахин санхүүжилт, эрдэс баялгийн үнийн хэлбэлзлээс шууд хамаарах өндөр эрсдэлтэй хэвээр байна.	Дунд
4	Зардлын бүтэц үр ашигтай, үр дүнтэй байх	Зардлын үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, төрийн оролцоог багасгах бодлого баримталж байгаа ч төсвийн алдагдлыг бууруулах, хөрөнгө оруулалтын үр дүнг хянах механизмыг илүү боловсронгуй болгох шаардлагатай.	Дунд
5	Төсвийн хуваарилалт бодит хэрэгцээнд суурилсан байх	Төсвийн төлөвлөлтийг хэрэгцээнд суурилах зарчмыг нэвтрүүлэхийг зорьж, бүс нутгийн болон хүний хөгжилд анхаарсан боловч санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд эрсдэлтэй, салбар хоорондын тэнцвэртэй байдлыг хангах шаардлагатай байна. Түүнчлэн бодлогын хувьд чухал боловч санхүүжилт нь тодорхойгүй зорилтууд цөөнгүй байна.	Хязгаарлагдмал

Эх сурвалж: Хууль тогтоомжид үндэслэн ТТБЗ-ийн хийсэн үнэлгээ

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд эдийн засгийн өрсөлдөх чадвар, өрхийн орлогыг дэмжих, инфляцыг тогтвортой байлгах үндсэн зорилтуудыг тусгаж, Төсвийн тухай хуулийн шаардлагыг **ерөнхий түвшинд хангасан боловч хөрөнгө оруулалтын үндэслэл, нэгж төслийн үр ашгийн тооцоо, үр дүн, зардал-үр дүнгийн хамаарал сул** буюу төсвийг тооцож төлөвлөгөөнд тусгахдаа шалгуур үзүүлэлт нь үр дүнтэй шууд холбоотой байх зарчмыг баримтлаагүй байна.

Мөн уг төлөвлөгөө нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан **зохион байгуулалт, логик уялдаа, бодлогын шатлалтай холбогдох шаардлагыг харьцангуй сайн хангасан** хэдий ч Төсвийн тухай хуулийн **хөрөнгө оруулалтын үр ашгийн үндэслэл, хяналт-шинжилгээний тогтолцоо, үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй холбоотой шаардлагыг бүрэн хангаагүй** байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд тухайлбал, “Алсын хараа 2050”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2026-2028 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, **төсвийн зарлагын хоорондын уялдаа, хамаарлыг авч үзвэл учир дутагдалтай байна.**

Засгийн газраас 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөлөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 36.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 31.9 хувь байхаар УИХ-д өргөн мэдүүлсэн. Түүнчлэн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдлээр улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 34.8 их наяд төгрөгт буюу ДНБ-ий 30.4 хувьд хүрэхээр байна. Бодит байдалд экспортын болон төсвийн гүйцэтгэл төсөөлж буй хэмжээнээс буурах, төсвийн орлого тасалдах, улмаар улсын төсвийн алдагдал нэмэгдэх, 2027 оны хөгжлийн болон төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан ч орлого, санхүүжилтийн тасалдлын улмаас **хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилга объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх магадлал өндөр байна.**

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд урт хугацааны хөгжлийн бодлого нь зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс, харин дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээс бүрдэхээр тогтоосон.

Энэхүү хуулийн 6.7, 6.8, 6.9, 6.10-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг *нэн тодорхой, харилцан уялдаатай боловсруулж баталсан байх*, тэдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтууд, төсөл, хөтөлбөрийг *хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийн тооцооллыг урьдчилан хийсэн байхыг* шаарддаг. Ингэснээр чухам ямар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэдэн онд, ямар хэмжээний хөрөнгө шаардлагатай, энэ эх үүсвэрийг нийт эдийн засагт дарамт учруулахгүй, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүйгээр бүрдүүлэх боломжтойг тодорхойлсноор макро эдийн засгийн зохистой байдал, тэнцлийг хангахуйц хөгжлийн бодлого боловсруулах нөхцөл бүрдэх юм. *Гэвч төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, мониторинг, тайлагналын аль ч шатанд доголдол гарсан хэвээр байна.*

Хөгжлийн бодлогын залгамж чанар хангалтгүй байна. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төсөлд 15.3 их наяд төгрөгийн 124 төсөл, 186 арга хэмжээг тусгажээ. Гэвч өмнөх жилүүдийн (2024-2025) төлөвлөгөөний гүйцэтгэл 40-60 хувьтай байсан болон эдийн засгийн суурь нөхцөлөөс үзэхэд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг *бүхэлд нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал* юм. Үүний шалтгааныг санхүүжилтийн дутагдал ба төсвийн эрсдэл, эдийн засгийн гадаад хүчин зүйлс, бүтэц, зохион байгуулалт болон засаглалын сул талтай холбон үзэж болохоор байна.

Хүснэгт 5. Бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Бодлого	ТЕЗ-ийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж хувь
Нэг. Эдийн засгийн бодлого	12	47.0
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	33.3
Гурав. Хүний хөгжлийн бодлого	8	85.0
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	73.3
Нийт	29	59.7

Эх сурвалж: (МУЗГ, 2026)

Эндээс харвал 2027 оны хөгжлийн бодлогын хэрэгжилт хэрхэн хангагдах нь тодорхойгүй байдалтай байна. Тиймээс өмнөх жилийн хөгжлийн бодлогын хэрэгжилт түүний шалтгааныг тодорхойлж дараа жилийн хөгжлийн бодлогод түүний сул талыг хэрхэн арилгах, арга зам, шийдлийг тусгадаг болох шаардлагатай байна.

Дараагийн асуудал нь хөгжлийн бодлогын зорилтуудын тогтвортой байдал юм. “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль нь Үндсэн хуулийн “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх” зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Иймээс улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хувьд бодлогын тэргүүлэх зорилтууд хэрхэн тодорхойлогдож байгааг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл

д/д	2024 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилтууд	2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилтууд	2026 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилтууд	2027 оны хөгжлийн төлөвлөлтийн тэргүүлэх зорилтууд
1	Экспортыг нэмэгдүүлнэ.	Эдийн засгийн бодлого	Эдийн засгийн бодлого	Эдийн засгийн чөлөөлөлт
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	Хүний хөгжлийн бодлого	Хүний хөгжлийн бодлого	Ногоон хөгжлийн чөлөөлөлт
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлого	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлого	Авлигын эсрэг чөлөөлөлт
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.			
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.			
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.			
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.			

Засгийн газраас хэрэгжүүлэхээр зарлаад буй чөлөөлөлтийн асуудлыг зарчмын хувьд буруутахгүй байна. Эдгээр асуудал нь Монгол Улсын өмнө нэн даруй тулгамдсан төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлийг дэмжих, авлига хээл хахуулийг бууруулахад чиглэж байгаа бөгөөд бодитойгоор хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай зүйлс мөн. Мөн өмнөх зорилтуудтай зарим талаараа агуулгын хувьд нийцэж байгааг дурдах хэрэгтэй. Хэдий тийм ч хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, бодлогын тогтвортой байдлыг хадгалах асуудлыг цаашид улам сайжруулах шаардлагатайг дурдах нь зүйтэй.

ДӨРӨВ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БА ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УЯЛДАА

Зарчим:Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5.2.5-д “тэнцвэртэй байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго,

зорилтууд, үйл ажиллагааг тодорхойлохдоо хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалсан байхыг”, 5.2.12-т “төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг”

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хавсаргасан “Монгол Улсын хөгжлийн 2027 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” (Хавсралт 1) нь Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилготой гэжээ.

“Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг байхаар хуульчилсан бөгөөд Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэл, үндэсний 10, салбарын 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85, хөтөлбөрийн 200 үр дүн, нийт 330 үр дүнг тодорхойлсон.” хэмээн хөгжлийн төлөвлөгөөнд үндсэн агуулгыг тусгасан.

Хүснэгт 7. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, үндэсний үр дүн

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН
Нэг. Эдийн засгийн чөлөөлөлт	Зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийг өрсөлдөөнтэй болгон төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжих, бизнесийн орчныг тогтвортой эрх чөлөөтэй болгож, татвар, төсвийн шинэчлэлийг хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжин, болзошгүй эрсдэлийг хохирол багатай даван туулах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүхий эдийн засгийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.
Үндэсний үр дүн	Эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг хадгалж, үндэсний өрсөлдөх чадварын индексийг 65 дугаар байрт эрэмбэлэгдэж байгааг 7 байраар ахиулна.
Хоёр. Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт	Зөвшөөрлийн тогтолцоог хялбарчлан, төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг оновчлон хүнд суртлыг бууруулж, суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгон эрх зүй, дүрэм журмыг чөлөөлнө.
Үндэсний үр дүн	Хүний хөгжлийн индекс 2025 онд 0.756 байгааг 2027 онд 0.781 хүргэж, дундаж давхаргын эзлэх хувийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ. Мөн Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индекс 49 хувь байгааг 52 хувьд хүргэж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ.
Гурав. Ногоон хөгжлийн чөлөөлөлт	Эрчим хүчний хараат байдлыг бууруулан, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр, айл өрхийн нарны хавтан зайн хураагуур, бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлж, ногоон дэд бүтцийг хөгжүүлэн, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шинэ боломжийг бий болгох, ногоон дата төв байгуулах, ногоон хөгжлийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.

Үндэсний үр дүн	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс 2025 онд 37.2 оноотой байгааг 2027 онд 40 оноонд хүргэж, орон нутгийн хөгжлийн индекс 0.506 байгааг 0.553-д хүргэнэ.
Дөрөв. Авлигын эсрэг чөлөөлөлт	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний хиймэл оюуныг хөгжүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж, цахим засаглал, ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлж, хариуцлагын механизмыг сайжруулан, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэн хууль давсан журмуудыг үе шаттайгаар бууруулж авлигын эсрэг чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.
Үндэсний үр дүн	Засаглалын үзүүлэлтээр 2025 онд 114 дүгээр байрт байгааг 2027 онд 7 байраар ахиулж, дэлхийн мэдлэгийн индекс 39.2 оноог 50 оноонд хүргэнэ.

Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон хөгжлийн төлөвлөгөөний зорилт, үр дүнгийн уялдаах сайжруулах шаардлагатай. Засгийн газраас өргөн барьсан хөгжлийн төлөвлөгөөний агуулга нь чөлөөлөлт рүү чиглэсэн гэдгийг өмнө дурдсан. Гол нь эдгээр чөлөөлөлтийг үзэл санаа нь үндэсний үр дүнг хэрхэн бий болгох, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Эндээс аль чөлөөлөлтөөр аль үр дүнг бий болгох асуудлыг тодорхой болгох шаардлага харагдаж байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үндсэн 8 бүлгээр буюу 1) Хүний хөгжил, 2) Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл, 3) Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, 4) Байгаль орчин, ногоон эдийн засаг, 5) Төрийн бүтээмж, засаглал, 6) Бүсийн хөгжил, 7) Үндэсний өрсөлдөх чадвар, 8) Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун гэсэн найман бүлэгт хамаарах **үндэсний 10 үр дүн, салбарын 35 үр дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд 67 үр дүн, хөтөлбөрийн 158 үр дүнд хүрэхээр тооцсон** байна. Тэргүүлэх чиглэл, үндэсний үр дүн болон бусад түвшинд уялдаа холбоог дээрээс доош зарчимд үндэслэн хангах шаардлагатай байна.

Бодлогын тэргүүлэх чиглэл (чөлөөлөлт) ба жилийн хөгжлийн төлөвлөгөөг харилцан уялдаатай боловсруулахыг хичээсэн ч нийцэл нь бүрэн хангагдаагүй байна.

Жилийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” (МУХТЖҮЧ), “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан бодлогын 4 тэргүүлэх чиглэл буюу 4 чөлөөлөлтийг хийхээр (УИХ-ын тогтоолын төслийн 1-р хавсралт) боловсруулсан нь сайшаалтай. Гэвч “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө” (УИХ-ын тогтоолын төслийн 2-р хавсралт)-нд эдгээр тэргүүлэх чиглэл (чөлөөлөлт)-ээр бус, харин МУХТЖҮЧ-ийн үндсэн 8 бүлгээр ангилж, үндэсний ба салбарын үр дүнгүүд, эдгээрийн төлөө төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнг тодорхойлсон байна. Эндээс УИХ-ын тогтоолын төслийн 1-р хавсралтад тусгагдсан дөрвөн чөлөөлөлтийг бодлогын тэргүүлэх чиглэл болно гэж тодорхойлсон бол 2-р хавсралтад байгаа жилийн хөгжлийн төлөвлөгөөний 8 бүлэгт хамаарах үр дүнг хангахад чиглэсэн ажлууд нь салбарын төлөвлөлт (эдийн засаг, дэд бүтэц, нийгэм, байгаль орчин, засаглал, бүсийн хөгжил, шинжлэх ухаан, технологи гэх мэт) байдлаар нэгтгэгдсэн байна. Тиймээс хавсралт 2-т тусгасан төсөл арга хэмжээнүүд нь урт дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаатай хийгдсэн боловч тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилт, үндэсний үр дүнгийн алинтай нь холбоотой болох нь тодорхойгүй байна.

Ийнхүү бодлогын тэргүүлэх чиглэл ба жилийн хөгжлийн төлөвлөгөөний нийцэл хангалтгүй байгаа нь **нэг чөлөөлөлт олон бүлэгт “тараагдаж”, үндэсний хэмжээнд үр дүн гарахгүй**

буюу нэгдсэн шинэчлэл болж чадахгүй хэрэгжилт хангалтгүй үлдэх, эсвэл нэг бүлэг буюу салбарын үйл ажиллагаа хэд хэдэн чөлөөлөлттэй давхар холбогдож, салбарын үр дүн тодорхой харагдахгүй болох, хэрэгжилтийн түвшинд бодит уялдаа хангагдахгүй байх үр дагаврыг үүсгэхээр байна. Тухайлбал, эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт нь боловсрол, эрүүл мэндийн салбар, ажил эрхлэлт, орлого нэмэгдүүлэх чиглэлээр салбаруудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, зардлын жагсаалт байдлаар жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаа юм.

Түүнчлэн бодлогын тэргүүлэх чиглэл (чөлөөлөлт) тус бүрийн хүрээнд тодорхойлсон зорилт, үр дүнг “Товч танилцуулга”-д дурдсан хэдий ч жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, суурь болон зорилтот түвшин, төсөвтэй холбож уялдуулаагүй тул *тодорхой чөлөөлөлтийн төлөө хэн, хэрхэн хариуцлага хүлээх нь тодорхойгүй байна.* Энэ нь жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа *үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйд тулгуурласан гэх боловч уг арга зүйн гол онцлог болох “логик уялдаа”-г хангаагүй, “үр дүнгийн хүрээ”-г системтэйгээр холбох шаардлага өндөр байгааг илтгэж байна.*

ТАВ.БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮН БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН УЯЛДАА, НИЙЦЭЛ

Зарчим:Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5.2.3-т."нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;" 5.2.5-т “тэнцвэртэй байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтууд, үйл ажиллагааг тодорхойлохдоо хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалсан байхыг” заасан.

2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тэргүүлэх 4 зорилт, үндэсний 10 үр дүн, салбарын 35 үр дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд 67 үр дүн, хөтөлбөрийн 158 үр дүнг тодорхойлсон нь нэгдмэл, цогц байх зарчмыг баримталж ажилласныг гэрчилж байна. Гэхдээ өмнөх жилүүдийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2027 оны төлөвлөлтийн баримт бичгүүдийн шинжилгээнд үндэслэн дараах зүйлсэд анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан үндэсний үр дүнгүүд нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн харилцан уялдаатай, цогц, тэнцвэртэй байх зарчмуудад нийцтэй байдлаар тодорхойлогдсон боловч тэдгээрийн оновчтой, тодорхой байдал, бусад түвшний үр дүнгүүдтэй уялдаатай байдал, шалгуур зэргийн хувьд анхаарах асуудлууд байсаар байна.

Үндэсний үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг оновчтой, тодорхой болгох шаардлагатай байна. Хөгжлийн төлөвлөгөөнд тодорхойлсон үндэсний 10 зорилтод эдийн засгийн чөлөөлөлтийг тодорхойлох боломжтой эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх талаар дурдсан “Өрсөлдөөнийг хязгаарлагч хүчин зүйлүүдийг бууруулах замаар зах зээл дэх төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2024 онд 72.5 хувь байгааг 2027 онд 79.0 хувьд хүргэхээр зорьж байна.” гэх мэт

бодит үр дүнг оруулах боломжтой юм. Үүнээс гадна үндэсний 10 үр дүнгийн хамгийн чухал гэж үзэж болох дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилтын хэмжүүр, суурь түвшин, хүрэх зорилт тодорхойгүй, ядуурлыг 27.1 хувиас хэд болгож бууруулах нь тодорхойгүй байна. Иймд үндэсний үр дүнг хэмжих шалгууруудыг улам сайжруулах, оновчтой болгох, тодорхой болгох шаардлага гарцаагүй байна.

Шалгуур үзүүлэлтүүдийн суурь ба зорилтот түвшинг бүрэн тодорхойлсон ч суурь түвшинг “0” гэж хийсвэрээр тодорхойлсон байх магадлалтай. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 (2026 онд 63) үр дүн, хөтөлбөрийн 158 (2026 онд 81) үр дүнг хангахын тулд **310** (2026 онд 300) **төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлэхээр төлөвлөн тэдгээрийг хэмжих **334** (2026 онд 331) **шалгуур үзүүлэлт** тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүрээр үр дүнгийн гэх суурь болон зорилтот (2027 онд хүрэх) үзүүлэлтүүдийг тодорхойлжээ ***Хавсралт 2. Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө ба үр дүнгийн үзүүлэлтүүдийн харьцуулсан шинжилгээ***

Гэхдээ нийт шалгуур үзүүлэлтийн 30.8 хувь буюу 103 шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг “0” гэж тусгасан байгаа нь үндэслэл багатай буюу хийсвэрээр тооцсон байх магадлалтай гэж үзэж байна. Жишээлбэл, ЖХТ-ний 6.2.2.3-т “Эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлнэ” гэсэн хөтөлбөрийн үр дүнг хангахын тулд 6.2.2.3.1-д “Эрчим хүчний хэрэглээ өндөртэй үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн жагсаалтыг шинэчлэн батлуулах, эрчим хүч хэмнэх үйл ажиллагаа, сурталчилгаа, сургалт таниулгыг өргөжүүлэн зохион байгуулах” арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд шалгуур үзүүлэлт нь “Үйл ажиллагааны хэрэгжилт”, хэмжих нэгж нь “хувь”, суурь он “2025”, суурь түвшин “0”, 2027 онд хүрэх зорилтот түвшин “100” гэж төлөвлөсөн байгааг үндэслэлтэй гэх нь эргэлзээтэй юм.

Томоохон төслүүдийн шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот үр дүн, санхүүжих дүн, эх үүсвэрийг тодорхойлоогүй нь хэрэгжих эсэхийг эргэлзээтэй болгож байна. Засгийн газрын зүгээс Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 3.5.1.1-д “Алт цэвэршүүлэх үйлдвэр барих” гэсэн төслийг тусгасан бол 2027 оны төлөвлөгөөний 5.1.1.1.4-т “Алт цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын бэлтгэл ажлыг хангах” гэж тусган “Бэлтгэл ажлын явцыг 0-30 хувь”-д хүргэхээр төлөвлөсөн боловч нийт болон 2027 онд шаардагдах санхүүжилтийн дүнг тодорхойлоогүй, гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ гээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам үндсэн хариуцагч болохоор байгаа нь уг төсөл хэрэгжих боломжтой эсэхийг эргэлзээтэй болгож байна.

Ийнхүү хөгжлийн бодлогын зорилтот үр дүнг үнэлэхэд шаардагдах үндсэн мэдээлэл болох шалгуур, түүний суурь ба зорилтот түвшний үзүүлэлтийг үндэслэлтэй тусгаагүй, системчилсэн хэлбэрээр гаргаагүй байгаа нь ***жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянаж, дүгнэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй*** юм.

Үр дүнгийн үзүүлэлтүүд SMART байх шаардлагыг бүрэн хангагдаагүй, зарим шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг бэлтгэхдээ бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, бодлогын үндэслэлд нийцүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, үр дүнгийн суурь болон зорилтот түвшинг гаргахыг хичээж буйг сайшаалтай. Гэвч эдгээр үр дүнгийн үзүүлэлтүүд SMART буюу хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байх шаардлагыг бүрэн хангагдаагүй, зарим шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, тухайлбал, “арга хэмжээний хэрэгжилт”, “барилгын ажлын гүйцэтгэл”, “төслийн хэрэгжилт” гэх мэтээр хэт ерөнхий тодорхойлогдсон, зарим хэрэгжиж буй төсөл,

арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн 2025 оны суурь түвшин “0” хэрнээ зорилтот түвшин нь бүгд 100 хувь гэх мэт байгаа нь хөгжлийн бодлого, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжгүй болгож байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг үндэсний 10 үр дүн бүрээр, салбар/төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн үр дүнтэй холбон тодорхойлсон боловч хөтөлбөрийн үр дүн болон төсөл, арга хэмжээний үзүүлэлттэй бүрэн уялдаагүй байна. Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө нь “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 2027 оны үзүүлэлтүүдийг хангаж байхын зэрэгцээ “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлж, 2027 оны үр дүнд хүрэхэд чиглэсэн байх ёстой.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” (УИХ-ын тогтоолын төслийн 3-р хавсралт)-ийг **Бодлогын тэргүүлэх чиглэл (чөлөөлөлт)-ийн 4 үр дүн** (7 шалгуур үзүүлэлт), **Төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 үр дүн** (88 шалгуур үзүүлэлт), **Хөтөлбөрийн 158 үр дүн** (247 шалгуур үзүүлэлт), **нийт 229 зорилтот үр дүнтэй, 342 шалгуур үзүүлэлттэй**гээр боловсруулжээ. Эдгээр шалгуур үзүүлэлтийн **суурь түвшинг бүрэн тодорхойлж тусгасан** бол **зорилтот түвшингийн** тухайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн **8.0 хувь**, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн **4.5 хувь нь тодорхойгүй** байна. Үүнээс гадна **“Тэргүүлэх чиглэлийн буюу 4 чөлөөлөлтийн үр дүн”** гэж тодорхойлсон 7 шалгуур үзүүлэлтийн суурь, зорилтот түвшин нь 2027 оны **үндэсний үр дүнгийн үзүүлэлт болж орсон ч салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүнг** хангахын тулд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний **шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь болон зорилтот түвшний үзүүлэлттэй бүрэн уялдаагүй байна.**

ЗУРГАА. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ЭХ ҮҮСВЭР

Зарчим:Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5.2.6-д “нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ байгалийн баялаг, түүхий эд, хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, ур чадвартай ажиллах хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд тусгахыг” гэж заасан.

Монгол Улсын 2027 оны жилийн төлөвлөгөөний товч танилцуулгад “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төсөлд 15.3 их наяд төгрөгийн 124 төсөл, 186 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа.” (МУЗГ, 2026), Мөн дэлгэрэнгүй танилцуулгад “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнг хангах нийт 310 төсөл, арга хэмжээ (үүнд 124 төсөл, 186 арга хэмжээ) -г уялдуулж тусгасан.” гэж дурдсан. Төлөвлөгөөний хавсралт 1 дахь мэдээлэлд харахад эдгээр хөрөнгө оруулалт, тэдгээрийн санхүүжилттэй холбоотой дараах асуудлуудыг дурдах шаардлагатай гэж үзлээ.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо олон, тухайн жилд шаардагдах төсвийн санхүүжилтийн дүн хэт өндөр байгаа нь жилийн хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлт бодит бус төдийгүй хэрэгжилт хангалтгүй байх үндэслэл

болохоор байна. Засгийн газар Монгол Улсын хөгжлийн 2027 төлөвлөгөөний төсөлдөө “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 8 бодлогын чиглэлийн хүрээнд нийт 65.5 их наяд төгрөгийн санхүүжилтийн өртөг бүхий 326 (Санхүүжилтийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардсан (310+16) тоогоор) төсөл, арга хэмжээнд 2027 онд 15.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг тусгажээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Бодлогын чиглэл болон төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилт /сая төгрөг/

Бодлогын чиглэл	Төсөл, арга хэмжээ	Нийт санхүүжилт	Тухайн жилд шаардагдах санхүүжилт
Хүний хөгжил	59	4,114,979.7	1,380,194.1
Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл	56	3,852,196.9	858,664.7
Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил	88	40,197,547.0	10,562,231.5
Байгаль орчин, ногоон эдийн засаг	36	5,749,220.8	543,327.8
Төрийн бүтээмж, засаглал	50	2,287,258.9	298,498.9
Бүсийн хөгжил	16	8,947,549.3	1,567,371.5
Үндэсний өрсөлдөх чадвар	14	111,096.2	45,256.3
Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун	7	289,000.0	24,446.5
Нийт	326	65,548,848.8	15,279,991.3

Эх сурвалж: ЭЗХЯ, УИХ-ын тогтоолын төслийн 2 дугаар хавсралт

Дээрх хүснэгтээс харахад нийт төслийн 26.9 хувь нь эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд, 18.0 хувь нь хүний хөгжилд, 17.1 хувь нь нийгмийн хөгжил, үндэсний нэгдэл үнэт зүйлд, 15.3 хувь нь төрийн бүтээмж, засаглалын бодлогод, 11 хувь нь байгаль орчин, ногоон эдийн засагт, 4.9 хувь нь бүсийн хөгжилд, 4.2 хувь нь үндэсний өрсөлдөх чадварт, 2.1 хувь нь шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун ухааны чиглэлд тус тус хэрэгжихээр тусгагджээ. Харин эдгээр бодлогын чиглэлүүдэд 65.5 их наяд төгрөг шаардлагатай байгаагаас 23.3 хувь буюу 15.3 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах төсөл, арга хэмжээг 2027 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гэтэл Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг гүйцэтгэлээр нь авч үзэхэд нийт 326 төсөл, арга хэмжээ 61 хувийн гүйцэтгэлтэй, 180 төсөл, арга хэмжээнд шаардагдах төслийн санхүүжилтийн 9.2 их наяд төгрөгөөс 5.4 их наяд төгрөгийг санхүүжүүлжээ¹. Үндэсний аудитын газрын “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайланд “2.7 Хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт хангалтгүй байгаа нь төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээ улсын төсөвт бүрэн тусгагдаагүй, 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр санхүүжилт хасагдаж, зарим хариуцагч татан буугдсан, төр, хувийн хэвшлийн түншлэлээр

¹ УИХ-ын тогтоолын төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 11-р хуудас.

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч тодорхойгүй зэрэг шалтгаантай байна” гэж дурдсан нь жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээний төлөвлөлт ба төсөвлөлт нь бодит бус байгаагаас шалтгаалан хэрэгжилт болон санхүүжилтийн гүйцэтгэл нь хангалтгүй гарч байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмын 5.1.6-д “нөөц эх үүсвэрт үндэслэсэн байх” 5.1.17-д “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим”-тай нийцэхгүй байна. Энэ нь жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодитойгоор зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн, хэрэгжих өндөр магадлалтай, ирэх жилийн төсөвт санхүүжилт нь бүрэн суухаар байгаа, эсвэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хэрэгжүүлэхээр тохирсон гэрээ, хэлэлцээртэй төслүүдийг нарийвчлан шалгасны үндсэн дээр тусгаж оруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг эхнээс нь зөв тодорхойлж тусгахгүй байгаа нь хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Дээр дурдсан 326 төсөл, арга хэмжээний нийт санхүүжилт болох 65.5 их наяд төгрөгийн санхүүжилтийг эх үүсвэрээр нь авч үзвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний эх үүсвэрээр 6.1 их наяд төгрөг, дотоодын хөрөнгө оруулалтаар 8.99 их наяд төгрөг, гадаадын хөрөнгө оруулалтаар 18.4 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 635.8 тэрбум төгрөг, үлдэх 31.4 их наяд төгрөгийн хөрөнгийг улсын төсөв, гадаад зээл, тусламж, бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан байна. Харин 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд шаардагдах 15.3 их наяд төгрөгийн санхүүжилтийн 2.2 их наяд төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, үлдэх 13.1 их наяд төгрөгийг гадаад, дотоод хөрөнгө оруулалт, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тооцжээ. Эндээс харахад жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг эх үүсвэрийн төрөл болгоноор тодорхой зааж өгөхгүй байгаагаас шалтгаалан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт болон санхүүжилтийн гүйцэтгэл нь дутуу гарч байна гэж үзэж байна. Тухайлбал, “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн 2-р хавсралт болох “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний хүснэгтийн “Санхүүжилтийн эх үүсвэр” гэсэн баганад (i) улсын төсөв, (ii) гадаадын зээл, (iii) гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, (iv) гадаадын тусламж, (v) гадаадын хөрөнгө оруулалт, (vi) дотоодын хөрөнгө оруулалт, (vii) орон нутгийн төсөв, (viii) гадаадын зээл, гадаадын тусламж, бусад эх үүсвэр, (ix) төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, (x) улсын төсөв, бусад эх үүсвэр, (xi) улсын төсөв, гадаадын тусламж, (xii) улсын төсөв, дотоодын хөрөнгө оруулалт, (xiii) улсын төсөв, дотоодын хөрөнгө оруулалт, (xiv) улсын төсөв, орон нутгийн төсөв, (xv) бусад эх үүсвэр зэргээр 15 ангиллаар, давхардсан төдийгүй зөрүүтэй байдлаар ангилж байгаа нь санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойгүй, бодит бус байлгах нэг үндэслэл болж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20.2-т хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн 6 эх үүсвэрийг заасан хэдий боловч энэ нь өөрөө төсвийн болон эдийн засгийн ангиллын шаардлагад нийцэхгүй байна. Тийм учраас дээрх хуульд өөрчлөлт оруулах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг нь тов тодорхой болгож зааж өгөх, жишээлбэл, (1) улсын төсөв, (2) орон нутгийн төсөв, (3) гадаад зээл, (4) гадаад тусламж, (5) дотоодын хувийн хэвшил болон ТХХТ (6) гадаад хөрөнгө оруулалт, (7) хамтарсан санхүүжилт гэж тодорхой зааж өгөх шаардлагатай (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, эх үүсвэрийн төрлөөр

№	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Төсөл, арга хэмжээ	Нийт санхүүжилт сая.төг	Нийт санхүүжилтэд эзлэх хувь	Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилтэд эзлэх хувь
1	Бусад эх үүсвэр	14	614,948.60	0.9%	339,474.15	2.2%
2	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	150,000.00	0.2%	100,000.00	0.7%
3	Гадаадын зээл	38	20,290,981.18	31.0%	4,332,757.13	28.4%
4	Гадаадын зээл, Гадаадын тусламж, Бусад эх үүсвэр	1	2,640,075.90	4.0%	349,385.42	2.3%
5	Гадаадын тусламж	10	1,202,514.53	1.8%	237,158.57	1.6%
6	Гадаадын хөрөнгө оруулалт	11	18,457,826.22	28.2%	3,258,240.02	21.3%
7	Дотоодын хөрөнгө оруулалт	20	8,997,373.96	13.7%	2,561,796.17	16.8%
8	Орон нутгийн төсөв	3	635,800.00	1.0%	175,200.00	1.1%
9	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ	15	6,136,831.86	9.4%	1,696,837.99	11.1%
10	Улсын төсөв	205	6,397,311.52	9.8%	2,215,816.81	14.5%
11	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	1	5,500.00	0.0%	3,140.00	0.0%
12	Гадаадын зээл, Гадаадын тусламж, Бусад эх үүсвэр	1	12,055.00	0.0%	3,455.00	0.0%
13	Улсын төсөв, Гадаадын тусламж	3	2,330.00	0.0%	1,430.00	0.0%
14	Улсын төсөв, Дотоодын хөрөнгө оруулалт	1	-	0.0%	-	0.0%
15	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	2	5,300.00	0.0%	5,300.00	0.0%
НИЙТ		326	65,548,848.77	100.0%	15,279,991.26	100.0%

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол, 2027 он

Дээрх мэдээллээс дараах зүйлсийг тодруулах шаардлагатай байна. Үүнд:

1. **Нийт санхүүжилтийн дүн тодорхойгүй 5 төсөл, арга хэмжээ байгаа** бөгөөд үүний дотор мега төслүүдийн хэмжээнд тооцогдож байгаа зарим төслүүд орсон байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын ажлыг өргөтгөх, Багануур үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд хүрэн хагас кокосны эрчим хүчний үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх, арьс шир боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт төслүүдийн санхүүжилтийн дүн тодорхойгүй байна.
2. **Хоёр буюу түүнээс дээш эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ 462.6 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 2.7 хувийг эзэлж байна.** Жилийн хөгжлийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй танилцуулгад тухайн төсөл, арга хэмжээнд аль эх үүсвэрийг хэдий хэмжээгээр дайчлан татах талаар тодорхой тоон мэдээллийг тусгаагүй байна. ҮАГ-ын дүгнэлт, өмнөх жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлээс харахад эдгээр нь хэрэгжилтийн түвшинд сөргөөр нөлөөлдөг болохыг анхаарах шаардлагатай.

3. ***Төр, хувийн хэвшлийн түншлэлээр 2027 онд нийт 15 төслийг 1.7 их наяд төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь нийт санхүүжилтийн 11.1 хувийг эзэлж байна.*** Хуульд зааснаар аливаа төсөл, арга хэмжээ хариуцах эзэнтэй, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл нь батлагдсан байх шаардлагатай бөгөөд хариуцах төрийн байгууллагыг заасан боловч бусад мэдээллүүдийг тодорхой тусгаагүй байна.
4. ***Гадаадын зээл, тусламжаар нийтдээ 53 төсөл, арга хэмжээг 4.9 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.*** Хөшгийн хөндий-Мандалговь чиглэлийн авто зам, Чингис Хаан олон улсын нисэх буудлын өргөтгөл шинэчлэлийн бэлтгэл ажил гэх мэт төслүүдийн нийт санхүүжилтийн дүнгийн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
5. ***Гадаадын зээлээр 38 төсөл, арга хэмжээг 20,290.9 тэрбум төгрөгөөр, тухайн жилд 4,332.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.*** Эдгээр төсөл, арга хэмжээний дотор дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, эсвэл төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой төслүүд байна. Тухайлбал, Солонго-I, II орон сууцны хорооллыг барьж байгуулахад 856.0 тэрбум төгрөг, Ухаалаг Засаг II төслийг хэрэгжүүлэхэд 1,451.3 тэрбум төгрөг, Баянхошуу дэд төв орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэхэд 1,444.9 тэрбум төгрөгийг гадаадын зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Цаашид цэвэр гадаадын зээлээр санхүүжих төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг хийхдээ хөрөнгө оруулалтын үр өгөөж, зориулалт, дотоодын аж ахуйн нэгжүүд эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх бололцоо гэх мэт шалгуурыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.
6. Үндэсний Аудитын газраас Монгол Улсын 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний ***хэрэгжилт 58.1 хувьтай, жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд шаардлагатай санхүүжүүлэлтийн 53.7 хувийг улсын төсвийн тухай хуульд тусгаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдсан хэвээр байна мөн Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 328 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 19,359.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 37.9 хувь буюу 7,336.4 тэрбум төгрөгийг 184 арга хэмжээнд зарцуулсан буюу санхүүжилтийн гүйцэтгэл хангалтгүй, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээнд урьдчилсан судалгаа хийгээгүй, төслийг түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжгүй, төлөвлөлтийн алдаатай, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээнүүд төлөвлөсөн, хэрэгжилт хангалтгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй 22 төсөл, арга хэмжээг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна***” гэж дүгнэсэн байна.

Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцах үндэсний болон салбарын үр дүнгийн үзүүлэлт, тухайн жилд шаардагдах хөрөнгийн эх үүсвэртэй уялдсан байдал хангалтгүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж, зорилтот түвшинд хүрэхгүй байх нэг үндэслэл болж байна. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 5.2.11-д зааснаар “төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх”, 5.1.17-д “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим”, 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 27.1.5-д “төсвийн төслийг хөтөлбөр, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр тодорхойлсон байх” гэсэн заалтуудаар жилийн хөгжлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хөтөлбөрт суурилсан төсөвлөлт буюу жилийн төсөв хооронд нийцтэй байх зарчмыг хуульчилсан. Цаашид Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан “улсын төсөв” гэсэн эх

үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2027 оны төсөв батлах үед Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3⁶, Төсвийн тухай хуулийн 27.1.8⁷-д заасан шаардлагуудад нийцүүлэх шаардлагатай. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн жилийн төсвийн төсөлд бүрэн тусгахгүй байх нь төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж, зорилтот түвшинд хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Хүснэгт 10. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагч буюу байгууллагуудаар, санхүүжилт /сая төгрөг/

№	Төсвийн ерөнхийлөн захирагчид, байгууллагын нэр	Төсөл, арга хэмжээ	Нийт санхүүжилт	Тухайн жилд шаардагдах санхүүжилт
1	Авлигатай тэмцэх газар	3	-	-
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	16	17,139,009.39	3,884,103.96
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	29	1,758,883.80	122,394.13
4	Батлан хамгаалах яам	9	462,446.00	157,819.65
5	Боловсролын яам	29	1,223,310.71	617,021.71
6	Боловсролын яам	1	-	-
7	Гадаад харилцааны яам	3	7,400.00	592.20
8	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	15	141,931.70	98,101.30
9	Ёс зүйн хороо	1	-	-
10	Зам, тээврийн яам	31	6,319,168.07	2,360,343.58
11	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	13	62,204.04	24,796.88
12	Монгол Улсын дээд шүүх	1	-	-
13	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц	1	300.00	89.00
14	Сангийн яам	7	754,308.80	158,865.40
15	Санхүүгийн зохицуулах хороо	2	70.00	70.00
16	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	16	981,638.60	289,792.56
17	Сонгуулийн ерөнхий хороо	2	28,965.00	14,966.15
18	Төрийн албаны зөвлөл	2	500.00	500.00
19	Улсын ерөнхий прокурорын газар	1	2,418.40	600.00
20	Улсын Их Хурлын Тамгын газар	2	-	-
21	Үндэсний аудитын газар	1	-	-
22	Үндэсний статистикийн хороо	2	-	-
23	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	11	3,277,875.86	517,118.25
24	Хууль зүй, дотоод хэргийн яам	16	406,163.30	151,704.03
25	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	32	823,729.06	413,500.95

26	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	6	1,583,036.55	67,465.98
27	Шадар сайдын Ажлын алба /Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/	15	669,584.09	154,515.79
28	Шадар сайдын Ажлын алба /Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа эрхэлсэн/	1	800.00	800.00
29	Шүүхийн ерөнхий зөвлөл	2	245,400.00	33,409.80
30	Шүүхийн сахилгын хороо	1	-	-
31	Эдийн засаг, хөгжлийн яам	10	2,912,705.90	378,353.22
32	Эрүүл мэндийн яам	21	2,310,126.21	488,553.37
33	Эрчим хүчний яам	24	24,436,873.28	5,344,513.36
	Нийт	326	65,548,848.77	15,279,991.26

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол, 2026 он.

Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийт улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх 326 төсөл, арга хэмжээнд 2027 онд 15.3 их наяд төгрөгийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг тусгажээ. Эдгээр Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 7.3 хувь, тухайн онд санхүүжүүлэх дүнгийн 34.6 хувь Эрчим хүчний яаманд ногдож байна.

Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн ач холбогдолтой төслүүдийг хурдан ашиглалт оруулах, үр өгөөжийг хүртэх үүднээс 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд гадаад зээлийн гэрээ, хэлэлцээртэй байгаа 65 төслийн ашиглалтыг нэмэгдүүлэх, төслүүдийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тэдгээр төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тухайн жилийн төсөвт бүрэн тусгадаг байх арга хэмжээ авах шаардлагатай. Засгийн газраас УИХ-д 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн танилцуулгад дурдсанаар 2026 оны байдлаар УИХ-аар соёрхон батлагдсан, хэрэгжилтийг нь Засгийн газар хариуцаж байгаа нийт 18.3 их наяд төгрөгийн амлалт бүхий гадаад зээлийн 24.2 хувийг ашигласан, 75.8 нь ашиглагдаагүй байна. Иймд эдгээр төслийг ач холбогдол, хэрэгцээ шаардлага дээр үндэслэн эрэмбэлж, 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд болон жилийн төсөвт шаардлагатай хэмжээгээр тусгах шаардлага үүсэж байна. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдэд онцгой ач холбогдол өгч тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад өмнөх 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд УАГ-аас хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг харгалзан санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоогүй төсөл, арга хэмжээнүүд оруулахгүй байхад анхаарах шаардлагатай. Үндэсний аудитын газрын “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайланд “1.15. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ТЭЗҮ шаардлагатай 102 төсөл, арга

хэмжээнээс 22 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ батлагдаагүй байгаа нь “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 6.10.2-т богино хугацааны буюу нэг жилийн төлөвлөгөөний санхүүжилтийн талаар “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэсэн заалтыг зөрчсөн байгааг дурдсан. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн зураг, төсөв нь баталгаажсан, ТЭЗҮ-тэй эсэх талаар дурдсан зүйл байхгүй байна. Энэ нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөр байна.

ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ТОМООХОН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР

Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд эдийн засагт эергээр нөлөөлөх томоохон хөтөлбөр, төслийн талаар нэлээд өндөр ач холбогдол өгч байгаа талаар дурдсан. Жишээлбэл, Барилгын салбарт томоохон бүтээн байгуулалтын төслүүд салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, Дулааны V цахилгаан станц, Төв аймгийн Баян суманд баригдах 660МВт ДЦС-ын бүтээн байгуулалтын ажил эрчимжихийн зэрэгцээ орон сууцны зориулалттай зээлийн эрэлтийг дагаж орон сууцны барилгын хөрөнгө оруулалт нэмэгдэж, бүтээн байгуулалтын ажлыг дэмжсэнээр салбарын өсөлтийг дэмжихээр байна.

Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийнхөө дагуу тодорхойлсон бодлогын тэргүүлэх дөрвөн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан томоохон төслүүдийг авч үзвэл:

1. ЗГҮАХ-т Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж заасан бөгөөд УИХ-аас 2026 оны 3 дугаар сард Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан 19.5 км төмөр замын хэлэлцээрийг соёрхон баталснаар бүтээн байгуулалтын ажил 5 дугаар сараас эхэлсэн боловч ЭЗХЯ-ны мэдээлснээр ажлын явц өнөөгийн байдлаар ердөө 4 хувьтай байна. 2026 оны төлөвлөгөөнд Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр зам болон ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих, “Шивээхүрэн-Сэхээ” хил холболтын төмөр зам барих талаар огт дурдаагүй, харин 2027 оны төлөвлөгөөнд эдгээр төслийг ТХХТ-ээр хэрэгжүүлэхээр тусгасан нь санхүүжилтын баталгаа биш болно.
2. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг барих төслийн хувьд 2025 оны төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэргүйгээр Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийх, 2026 оны төлөвлөгөөнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 689 тэрбум, 2027 онд ТХХТ-ийн гэрээгээр 418.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх гэж тусгасан ч уг төслийн нийт өртөг 2.09 их наяд төгрөг гэж тооцсоноос харахад хугацаандаа хэрэгжих боломжтой эсэхийг эргэн харах шаардлагыг бий болгож байна..
3. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт анх тусгагдсанаас хойш жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөний зорилт болж ирсэн 776.4 тэрбум төгрөгийн

- өртөгтэй Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төсөлд улсын төсөв, гадаадын зээлээр 2025 онд 100 тэрбум, 2026 онд 178 тэрбум, 2027 онд 121.1 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон нь мөн эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байгаа юм. Гэхдээ “Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх анхдагч хууль”-ийн хүрээнд хэрэгжилт нь шийдэгдэх хүлээлттэй байна.
4. 2025 онд эхлүүлж, 3.7 их наяд төгрөгийн төсвөөр 2032 онд бүрэн дуусгахаар төлөвлөсөн Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц барих төсөлд 2025 онд 2 тэрбум, 2026 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасан ч 2027 оны төлөвлөгөөнд огт дурдаагүй байх бөгөөд Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох, “Байгаль нуур”-т үзүүлэх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан судалгааг ОХУ-ын эрдэмтэдтэй хамтран хийх, ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хороогоор шийдвэр гаргуулах ажил олон ажил жил дараалан хүлээгдэж байна.
 5. Говийн бүсийг усаар хангахад нэн чухал ач холбогдолтой “Орхон-Онги”, “Хэрлэн-Тооно” ус дамжуулах хоолойг барих төслийн тухайд 2025, 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд яг адилхан “Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслийн бэлэн байдлыг хангах” заалт тусгаж, “Орхон-Онги” төслийн эхний шатны “Онги-Цагаан бургастай” усан сан, ус дамжуулах хоолой барих төслийн бэлэн байдлыг хангахад 2025 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр 17.9 тэрбум, 2026 онд улсын төсвөөс 13.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн ч 2027 оны төлөвлөгөөнд санхүүжилт тавигдаагүй байна. Харин “Хэрлэн-Тооно” төслийн тухайд гол саад бэрхшээл бол одоогоор нарийн тооцож гаргаагүй их өндөр зардал, геополитикийн асуудалтай холбоотой үүсэх эрсдэл юм.
 6. 2022 оны судалгаагаар 7.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй байхаар тооцсон Эрэнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барих төслийг ЭЗХЯ-ны танилцуулгад “бэлтгэл хангах” төлөвт гэсэн байх хэдий ч уг төслийн талаар сүүлийн гурван жилийн хөгжлийн төлөвлөгөөнд дурдаагүй байна.
 7. 2026-2030 онд хэрэгжих Монгол, Францын хамтарсан Ураны төсөл нь 2025 онд Монгол Улсын Засгийн газар БНФУ-ын “Орано Майнинг” компанитай хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж, 2026 оны жилийн төлөвлөгөөнд гадаадын хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ураны ордыг ашиглах гэрээний хэрэгжилтийг хангахад гадаадын хөрөнгө оруулалтаар 779.6 тэрбум, 2027 онд 326.8 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон бөгөөд одоогоор хувьцаа эзэмшигчдийн гэрээг хөрөнгө оруулагч талтай байгуулах ажил хүлээгдэж байна. Монгол Улсын газрын ховор элементийн нөөцөд гуравдагч хөршүүд онцгой ач холбогдол өгч байгаа өнөө үед энэхүү төслийн эдийн засгийн төдийгүй геополитикийн ач холбогдол өндөр юм.
 8. 2029-2030 онд хэрэгжүүлж дуусгахаар анх төлөвлөж байсан Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор байгуулах төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй хэвээр байна.
 9. 2026-2029 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын бэлтгэл ажлыг хангахад 2025 онд 804.7 тэрбум, 2026 онд 501.7 тэрбум, 2027 онд 644.3 тэрбум төгрөгийг дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан боловч нийт өртөг 2.5 их наяд төгрөг шаардлагатай учир энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих боломжгүй харагдаж байна.
 10. Гангийн цогцолбор байгуулах төслийн тухайд 2026 оны жилийн төлөвлөгөөнд “Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах” гэж бичсэн ч санхүүжилт хуваарилаагүй төдийгүй

шалгуур үзүүлэлт, үр дүнгийн үзүүлэлт байхгүй хоосон мөр байна. Харин 2027 оны төлөвлөгөөнд энэ төслийг дурдаагүй бөгөөд танилцуулгад төсөл *бэлтгэл хангах* төлөвт, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй гэжээ.

11. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг гол зорилт болох Газрын тос боловсруулах цогцолбор байгуулах ажил 2016 онд эхэлж, 2028 онд төслийг дуусгахаар төлөвлөж байгаа ч одоогийн байдлаар хэрэгжилт нь 34 хувьтай байна. Гадаад зээлээр бүрэн санхүүжих энэ төслийн нийт өртөг 4.178,8 тэрбум төгрөг бөгөөд санхүүжилт жил, жилийн төлөвлөгөөнд туссан хэмжээгээр үргэлжлэх бол төлөвлөсөн хугацаандаа дуусах боломжгүй болно. Харин “Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх анхдагч хууль”-ийн хүрээнд санхүүжилтэд бодит ахиц гарах хүлээлттэй байгаа ч энэ төслийн хувьд тодорхойгүй олон асуудал тулгарч байгаа юм.
12. Алт цэвэршүүлэх үйлдвэрийг 276.8 тэрбум төгрөгөөр дотоодын хөрөнгө оруулалтаар барих зорилт дэвшүүлсэн боловч 2026 онд зөвхөн 1 тэрбум төгрөг тусгаж, 2027 онд санхүүжилт тавигдаагүй байна. Энэ төсөл 1998 оноос хойш яригдаж, үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт болсоор 2021 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан боловч одоо ч эхлэл төдий байгаа билээ. Түүнээс гадна төслийн хүчин чадлыг жилд 75 тонн алт цэвэршүүлэхээр тооцсон нь Монголбанк ганц удаа л 22 тонн алт худалдан авч байсантай харьцуулбал судалгаанд үндэслэсэн төсөл гэж үзэх боломжгүй юм.
13. 2024 онд ТЭЗҮ-ийг нь шинэчлэн баталсан “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төсөл”-ийг 2026 оны төлөвлөгөөнд бэлтгэл ажлыг хангана гэж ямар ч үр дүнгийн шалгуур үзүүлэлтгүй оруулж, 2027 оны төлөвлөгөөнд дурдаагүй орхисон байна. Энэ нь аливаа бодлого, зорилт судалгаа тооцоотой байх, шинжлэх ухааны үндэслэлтэй байх, эдийн засгийн хувьд үр ашигтай байх шалгуурыг хангаагүйн жишээ гэж үзэхэд хүргэж байна.

Ийнхүү санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байдлын улмаас төлөвлөсөн зорилтын ихэнх нь хугацаандаа хэрэгжих боломжгүй харагдаж байна. Түүнээс гадна өндөр өртөгтэй, хэрэгжих үндэслэл багатай, эдийн засгийн үр ашиг нь тодорхойгүй Арцсуурь-Шивээхүрэн чиглэлийн баруун босоо 1,255 км төмөр зам, Ханх-Хатгал авто зам зэрэг төслийг дурдаж болно. Энэ бүх баримт улс орны хөгжлийн бодлогыг нэгтгэн зангидах бодлого, төлөвлөлтийн чадавх сул байгааг харуулж байна.

УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэрийн тооцоолол хийгдсэн байх ёстой. Гэвч УИХ-аас Засгийн газарт өгсөн зарим үүрэг, даалгавар хэрэгждэггүй хэвээр байна. Тухайлбал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан УИХ-ын 21 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолж, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх”-ийг Засгийн газарт даалгасан. Гэвч УИХ-ын энэхүү тогтоол батлагдан гарснаас хойш ийм өртөг зардлын, эх үүсвэрийн тооцоолол хийгдсэн эсэх талаар тодорхой мэдээлэл өнөөг хүртэл байхгүй байна. Түүнчлэн ЗГҮАХ-ийг баталснаас хойш 4 сарын дараа буюу 2025 оны 1 дүгээр сард “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл”-ийг Засгийн газраас өргөн мэдүүлснийг УИХ шууд хүлээн авсан. Гэтэл энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ирэх 25 жилд нийтдээ 236.2 их наяд төгрөг, үүний дотор улс, орон нутгийн

төсвөөс 94.8 их наяд төгрөгийг зарцуулах шаардлагатай гэсэн тойм тооцоо хийсэн байдаг. Энэхүү ерөнхий төлөвлөгөөг 15 жилд хэрэгжүүлнэ гэж тооцвол улсын төсөвт жил бүр 6 их наяд төгрөгийн дарамт ирэхээр байгаа бөгөөд төсөв үүнийг даах боломжгүй юм.

Эдгээрээс үзвэл, Засгийн газар, нийслэл, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүд, нийт зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухам хэдий хэмжээний хөрөнгө, эх үүсвэр шаардлагатай талаарх тооцоо өнөөг хүртэл бүрэн тодорхой болоогүй байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хөгжлийн 2027 оны жилийн төлөвлөгөөний баримтуудад хийсэн шинжилгээний үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж, холбогдох зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт

- 1. Макро эдийн засгийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх шаардлага хэвээр байна.** 2025 оны эдийн засгийн гүйцэтгэлийн бүтэц, өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаас харвал 2026,2027 онуудад эдийн засаг 5.8 хувийн өсөлттэй байх нөхцөл хэр баталгаатай болох, 2026 оны эдийн засгийн өсөлтийн шалтгаан нь томоохон хөтөлбөр, төсөл, болон үйлчилгээний салбар байх боломжтой эсэх нь тодорхойгүй юм. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжих гол үндэс нь эдийн засгийн тогтвортой өсөлт, түүний бодитой таамаглал энэ өсөлтөд алдаа гаргахгүй байх, нөхцөл байдлыг бодитойгоор үнэлэх шаардлага өндөр байна.
- 2. Бодлогын уялдаа, хуулийн шаардлагыг хангаж байдал сайжирч байна.** Жилийн хөгжлийн төлөвлөгөө нь урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй зорилго, хэрэгжилтийн түвшинд уялдаатай байдал, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн зарчмыг хангах тал дээр ахиц дэвшил гарч байгаа нь цаашдаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд эергээр нөлөөлөх боломжтой юм.
- 3. Хөгжлийн тэргүүлэх зорилт, үндэсний үр дүнг оновчтой, тодорхой болгох шаардлагатай байна.** Хөгжлийн бодлогод тэргүүлэх чиглэл, түүний үр дүнг тодорхойлох үндэсний үр дүнг тодорхойлж байгаа боловч тэдгээр нь урт хугацааны хөгжлийн зорилго, зорилтыг шийдэхэд чиглэсэн байдал, тодорхой байдал, хэмжүүр нь бодитой зэрэг талаас анхаарах асуудлууд байсаар байгааг анхаарах. Энэ чиглэлд хувийн хэвшлийн оролцоо, ядуурал, дундаж давхарга гэх мэт эдийн засгийн, боловсрол, эрүүл мэнд гэх мэт суурь салбарын зорилго, үр дүнг оновчтой, тодорхой үзүүлэлтээр оруулах шаардлагатай.
- 4. Бодлогын уялдаа, стратегийн нийцэл үндсэндээ хангагдсан боловч хэрэгжилтийн түвшинд доголдолтой хэвээр байна.** Монгол Улсын хөгжлийн 2027 оны жилийн төлөвлөгөө нь урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа–2050”, Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй зорилгын түвшинд уялдсан боловч үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн уялдаа бүрэн хангагдаагүй байна. Тодруулбал хөгжлийн төлөвлөгөөний хавсралтад тусгагдсан арга хэмжээнүүд нь бүгд урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй хамаатай байдлаар уялдаатай байх

боловч тухайн жилийн хөгжлийн төлөвлөлтийн ямар тэргүүлэх чиглэл, ямар үндэсний үр дүнтэй уялдаатай нь тодорхойгүй байна.

5. **Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд SMART байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.** Жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 334 шалгуур үзүүлэлтийн зарим үзүүлэлт зорилтот түвшингүй, хэт ерөнхий, хэмжих боломжгүй байдлаар тодорхойлогдсон нь үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бодит боломжийг алдагдуулж байна.
6. **Санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн тооцоо бүрэн хийгдээгүй байна.** Төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл, арга хэмжээний 5 нь санхүүжилтийн эх үүсвэргүй, олон төслийн хувьд эх үүсвэрийн бүтэц тодорхой бус, хэт өөдрөг төсөөлөлд тулгуурласан нь хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мөн мега төслүүдийн хувьд төслийн нийт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, үр өгөөж тодорхой бус, зарим нь олон жил дараалан жилийн хөгжлийн төлөвлөгөөнд багтсан боловч хэрэгжилтийн бодит ахиц харагдахгүй байна.
7. **Төслийн сахилга бат, хөрөнгө оруулалтын үр ашигт хангалттай анхаарал хандуулах шаардлагатай байна.** Томоохон төсөл, хөтөлбөрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөв, хариуцах эзэн, байгууллага тодорхой бус, хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөжийн тооцоолол хангалтгүй байна. Энэ нь төсвийн хуваарилалт оновчгүй байх, хэрэгжилт зогсонги байдалд орох эрсдэлийг дагуулна.

Зөвлөмж

1. **Хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгийн хэмжүүрийг оновчтой, тогтвортой болгох, хариуцлагажуулах шаардлагатай.** Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаж байгаа тэргүүлэх чиглэл, үндэсний үр дүн нь урт хугацааны хөгжлийн зорилгод нийцтэй байхаас гадна оновчтой байх, хэмжүүр тодорхой байх, тогтвортой байх шаардлагатай байна. Жишээлбэл: ядуурлыг бууруулах зорилгыг тодорхой тавьж хүрч чадахгүй бол хариуцлага хүлээх эзэн нь тодорхой болгох гэх мэтээр.
2. **Хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай.** Хөгжлийн бодлого нь урт дунд хугацаан хөтөлбөртэй хэрхэн уялдаж байгааг зорилго, зорилтууд, үр дүнгийн түвшин бүрээр гаргах шаардлагатай байна. Тодруулбал хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бүр нь үндэсний үр дүнг хэрхэн дэмжих талаарх асуудлыг хөндөх шаардлагатай байна.
3. **Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг SMART зарчимд нийцүүлэн илүү боловсронгуй болгон сайжруулах.** Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжих боломжтой, бодитой, хугацаатай байдлаар тодорхойлж, шалгуур үзүүлэлт бүрд суурь болон зорилтот түвшнийг үндэслэлтэй тооцон тусгах, үйл ажиллагаа байдлаар тодорхойлогдсон, хэт ерөнхий шинжтэй үзүүлэлтүүдийг нарийвчлах шаардлагатай. Үүнээс гадна нэгдсэн шалгуур болох үндэсний үр дүнтэй нийцүүлэх асуудлыг анхаарч сайжруулах шаардлагатай байна.
4. **Хөрөнгө төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн тодорхой болгох.** Санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын тооцооллыг ил тод, бодитой болгож, эдийн засгийн үр өгөөжгүй, хэт өндөр өртөгтэй, эрсдэлтэй

төслүүдийг дахин нягталж, эрэмбэлж хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөлд тавих шалгуурыг нарийвчлан тодорхойлох нь чухал.

5. ***Төлөвлөлт ба төсөвлөлтийн уялдааг сайжруулж, Төсвийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангахад анхаарах.*** Жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрийн санхүүжилтийн дүн, эх үүсвэр, зарцуулалт, хэрэгжилтийн хугацаа зэрэг мэдээллийг Төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан нарийн тусгаж, төсвийн сахилга батыг сайжруулах, өрийн тогтвортой байдлыг хадгалахад илүү анхаарах нь зүйтэй.
6. ***Томоохон төслүүдийн хэрэгжих бодит боломж, шалгуур үзүүлэлтийг үнэлж, хэрэгжилтийн стратегийг тодорхойлох.*** Төсвийн хувьд онцгой ач холбогдолтой гэж үзэж буй хөгжлийн томоохон төслүүдийн шалгуур үзүүлэлт, санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл, үр өгөөжийг нарийвчлан үнэлж, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх стратегийг боловсруулж, огт судалгаагүй, ач холбогдол нь тодорхой бус төслүүдийг төлөвлөгөөнд тусгахгүй байх нь зохистой.
7. ***УИХ-аас Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн өмнөх тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг эргэн хянан, тайлагнах механизмыг бий болгох.*** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, эх үүсвэрийн үнэлгээ, өрийн ачаалал зэрэг асуудлаар УИХ-ын тогтоолоор өгсөн чиглэлүүдийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, тухайн баримт бичгүүдийн хэрэгжилт, нийцлийг үнэлэх талаар холбогдох төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна

Хавсралт 1. 2027 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, үндэсний үр дүн

д/д	Салбар/ТЕЗ/Хөтөлбөрийн нэр	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	"Зорилтот түвшин 2027 он"
1	Үндэсний үр дүн	Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Хүний хөгжлийн үзүүлэлт	-	Индекс	2024	0.756	0.781
2	Үндэсний үр дүн	Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.	Дундаж давхаргын эзлэх хувь	-	Хувь	2025	Тооцох	-
			Голч /медиан/ орлогын 50 хувиас доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь	10.2.1	Хувь	2024	15.8	14
			Жини коэффициент	-	Индекс	2024	0.29	0.28
3	Үндэсний үр дүн	Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлнэ.	Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн индекс	-	Хувь	2021	49	52
4	Үндэсний үр дүн	Нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.	Үндэсний сайн сайхан байдлын индекс	-	Хувь	2025	Тооцох	T+5%
			Ядуурлын хамралтын хүрээ	1.2.1	Хувь	2022	27.1	-
5	Үндэсний үр дүн	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгална.	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	8.1.1	Хувь	2025	6.8	6.3
			Нэг хүнд ногдох ДНБ	-	Ам.доллар	2025	7,320.00	8,600
6	Үндэсний үр дүн	Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	-	Индекс	2024	37.2	40.0
7	Үндэсний үр дүн	Зөв засаглалын үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтүүдийн дундаж	-	Эрэмбэ	2024	114	107
8	Үндэсний үр дүн	Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгана.	Орон нутгийн хөгжлийн индекс	-	Индекс	2024	0.506	0.553
		Орон нутгийн хүн ам	-	Хувь	2024	50.1	51.1	Орон нутгийн хүн ам
9	Үндэсний үр дүн	Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Олон улсын өрсөлдөх чадварын индекс	-	Эрэмбэ	2025	65	58
10	Үндэсний үр дүн	Эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлнэ.	Дэлхийн мэдлэгийн индекс	-	Индекс	2025	39.2	50
		ДНБ-д дунд болон өндөр технологийн үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь	9.b.1	Хувь	2024	6.6	8.45	ДНБ-д дунд болон өндөр технологийн үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь

Хавсралт 2. Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө ба үр дүнгийн үзүүлэлтүүдийн харьцуулсан шинжилгээ

Бүлгийн нэр	Үндэсний үр дүн	Салбарын үр дүн	Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл				Монгол Улсын хөгжлийн 2027 оны оны төлөвлөгөөний ХШҮ-ий үзүүлэлт									
			ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	ҮД-ийн үзүүлэлт		Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн			Хөтөлбөрийн үр дүн				
							Суурь түвшин	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		
I. ХҮНИЙ ХӨГЖИЛ	1. Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	1.1.1	2	4	4	4	3	3	3	7	7	7			
			1.1.2	2	11	20	20	20	4	4	3	12	12	12		
			1.1.3	3	6	6	6	6	2	2	2	5	5	5		
		Халдварт бус өвчлөлийг бууруулна.	1.2.1	9	16	18	18	18	1	1	1	29	29	28		
			1.2.2	3	4	4	4	4	2	2	2	4	4	2		
			2.1.1	3	4	4	4	4	1	1	1	6	6	6		
	2. Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.	Зохистой хөдөлмөр эрхэлж байгаа хүний тоог нэмэгдүүлнэ.	2.1.1	3	4	4	4	4	1	1	1	6	6	6		
			2.1.2	1	2	2	2	2	1	1	1	1	1	1		
			2.1.3.	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
		2.2.1.	2	2	2	2	2	2	1	1	1	2	2	2		
	Нийт			26	50	61	61	61	16	16	15	67	67	64		
	II. НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ	3. Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлнэ.	Үндэсний соёлын дархлааг бэхжүүлнэ.	3.1.1.	2	4	4	4	4	1	1	0	2	2	0	
3.1.2.				3	3	5	5	5	1	1	1	3	3	3		
4.1.1.				3	5	6	6	6	3	3	3	6	6	6		
4. Нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.		Хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлнэ.	4.1.1.	3	5	6	6	6	3	3	3	6	6	6		
			4.1.2.	2	4	5	5	5	1	1	0	3	3	3		
			4.2.1.	2	2	2	2	2	1	1	1	6	6	5		
		Хүний эрхийн баталгааг хангана.	4.2.2.	2	2	2	2	2	1	1	1	2	2	0		
			4.2.3.	2	3	3	3	3	1	1	1	4	4	4		
			4.2.4.	6	9	9	9	9	2	2	2	8	8	8		
		Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	4.3.1.	2	7	7	7	7	1	1	1	2	2	2		
			4.4.1.	4	9	9	9	9	1	1	1	4	4	3		
			4.4.2.	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
			4.4.3.	3	4	5	5	5	2	2	2	3	3	3		
			4.4.4.	1	2	2	2	2	1	1	1	1	1	1		
			Нийт	33	55	60	60	60	17	17	15	45	45	39		
		III. ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	5. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгална.	Боловруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	5.1.1.	1	7	7	7	7	1	1	1	1	1	1
					5.1.2.	2	5	5	5	5	1	1	1	6	6	6
				Уул уурхайн нийт үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	5.2.1.	2	7	7	7	7	1	1	1	4	4	4
5.3.1.	3				13	13	13	13	1	1	1	8	8	8		
Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.	5.4.1.			1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
	5.4.2.			1	1	1	1	1	1	1	0	1	1	0		
Санхүүгийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлнэ.	5.5.1.			1	1	1	1	1	1	1	1	1	2	2		
	5.6.1.			4	17	17	17	17	2	2	2	4	4	4		
Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	5.7.1.			4	30	30	30	30	6	6	6	8	8	8		
	5.7.2.			2	5	5	5	5	1	1	1	2	2	2		
Тээвэр, логистикийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	5.8.1.			1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
	Нийт			22	88	88	88	88	17	17	16	37	38	37		

Бүлгийн нэр	Үндэсний үр дүн	Салбарын үр дүн	Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөл						Монгол Улсын хөгжлийн 2027 оны оны төлөвлөгөөний ХШҮ-ний үзүүлэлт					
			ТӨЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	ҮД-ийн үзүүлэлт		Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн			Хөтөлбөрийн үр дүн		
							Суурь түвшин	Зорилгот түвшин	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин
IV.БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ	6.Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	Анхдагч экосистемийн гэнцвэрт байдлыг хадгалж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	6.1.1.	1	2	2	2	2	2	2	2	1	1	1
		Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.	6.2.1.	5	7	7	7	7	1	1	1	9	9	9
			6.2.2.	3	4	4	4	4	1	1	0	5	5	5
		Байгалийн нөөцийг судалж, хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулна.	6.3.1.	6	16	21	21	21	2	2	2	12	12	12
			6.3.2.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
	Нийт	17	32	37	37	37	7	7	6	29	29	29		
V.ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ	7.Зөв засаглалын үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.	Авлигыг бууруулна.	7.1.1.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
		Хууль, шүүхийн байгууллагын засаглалыг сайжруулна.	7.2.1.	4	5	5	5	5	2	2	2	4	4	4
			7.2.2.	4	4	4	4	4	1	1	1	4	4	3
			7.2.3.	1	1	1	1	1	2	2	2	1	1	1
			7.2.4.	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
		Төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	7.3.1.	1	2	3	3	3	1	1	1	1	1	1
			7.3.2.	3	3	3	3	3	1	1	1	3	3	3
			7.3.3.	1	1	1	1	1	1	1	1	1	0	1
			7.3.4.	3	3	4	4	4	1	1	1	5	5	5
			7.3.5.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
			7.3.6.	2	2	2	2	2	1	1	0	2	2	2
		Төлөөллийн байгууллагын асуудал оновчтой шийдвэрлэх чадавхыг сайжруулна.	7.4.1.	1	2	2	2	2	1	1	1	1	1	1
			7.4.2.	2	2	2	2	2	1	1	0	2	2	1
			7.4.3.	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
		Улс төрийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	7.5.1.	2	2	3	3	3	1	1	1	4	4	4
		Гадаад таатай орчныг бэхжүүлнэ.	7.6.1.	3	3	3	3	3	1	1	1	3	3	3
			7.6.2.	1	1	2	2	2	1	1	1	1	1	1
		Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	7.7.1.	3	8	8	8	8	1	1	1	3	3	3
		Цэргийн алба хаагчдад тодорхой чиглэлээр мэдлэг олгож, үр чадварыг нэмэгдүүлнэ.	7.7.2.	0	1	1	1	1	1	1	1			
	Нийт	37	48	52	52	52	21	21	19	41	40	39		
VI.БҮСИЙН ХӨГЖИЛ	8.Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгана.	Орон нутгийн засаглалыг бэхжүүлнэ.	8.1.1.	2	2	2	2	2	1	1	1	3	3	3
			8.1.2.	8	14	14	14	14	1	1	1	10	10	10
			Нийт	10	16	16	16	16	2	2	2	13	13	13
VII.ҮНДЭСНИЙ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР	9.Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Эдийн засгийн эрх чөлөөт сайжруулна.	9.1.1.	1	1	1	1	1	1	1	1	1	1	
			9.1.3.	1	1	1	1	1	1	1	1	1	1	
			9.1.4.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
		Засгийн газрын өрийг бууруулна.	9.2.1.	2	2	1	1	1	1	1	1	3	3	3
		Гадаад худалдааны хэмжээг нэмэгдүүлнэ.	9.3.1.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
		Чөлөөт бүсүүдийн худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.	9.3.2.	1	4	4	4	4	1	1	1	1	1	1
	Нийт	9	14	13	13	13	6	6	6	10	10	10		
VIII.ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ХИЙМЭЛ ОЮУН	10.Эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлнэ.	Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлэх, ашиглах үйл явцыг эрчимжүүлнэ.	10.1.1.	2	4	4	4	4	1	1	1	3	3	3
		Дижитал эдийн засгийг нэмэгдүүлнэ.	10.2.1.	2	3	3	3	3	1	1	1	2	2	2
			Нийт	4	7	7	7	7	2	2	2	5	5	5
НИЙТ				158	310	334	334	334	88	88	81	247	247	236

Хавсралт 3. 2027 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, үндэсний үр дүн

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүн
Нэг. Эдийн засгийн чөлөөлөлт	Зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийг өрсөлдөөнтэй болгон төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжих, бизнесийн орчныг тогтвортой эрх чөлөөтэй болгож, татвар, төсвийн шинэчлэлийг хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжин, болзошгүй эрсдэлийг хохирол багатай даван туулах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүхий эдийн засгийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.
Үндэсний үр дүн	Эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг хадгалж, үндэсний өрсөлдөх чадварын индексийг 65 дугаар байрт эрэмбэлэгдэж байгааг 7 байраар ахиулна.
Эрчим хүчний салбарт	Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны станц, Дулааны тавдугаар цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай УЦС барина
Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, Зөөвч-Овоо төслийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Ган үйлдвэрлэлийн цогцолборын талбайн бэлтгэл ажлыг эхлүүлнэ.
Тээвэр, логистикийн салбарт	Экспорт болон аялал жуулчлалын чиглэлийн авто замууд болон “Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хил холболтын төмөр зам барьж, хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлнэ.
Хөдөө аж ахуйн салбарт	Евроазийн эдийн засгийн холбоотой байгуулсан Худалдааны түр хэлэлцээр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан зураглалыг хэрэгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ. “Атар IV” аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид болон “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд арьс, ширний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.
Соёл, аялал жуулчлалын салбарт	Зам дагуух аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор байгуулж, Гурвансайхан 4D, Ховд, Мөрөн 4С нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.
Хоёр. Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт	Зөвшөөрлийн тогтолцоог хялбарчлан, төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг оновчлон хүнд суртлыг бууруулж, суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгон эрх зүй, дүрэм журмыг чөлөөлнө.
Үндэсний үр дүн	Хүний хөгжлийн индекс 2025 онд 0.756 байгааг 2027 онд 0.781 хүргэж, дундаж давхаргын эзлэх хувийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ. Мөн Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн индекс 49 хувь байгааг 52 хувьд хүргэж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг одоогийн түвшнээс 5 хувиар нэмэгдүүлнэ.
Боловсролын салбарт	“Цөөн хүүхэдтэй анги” бодлого баримталж, багийн болон хотхоны бага сургууль байгуулж, “Нэг багшид нэг AI туслах”-ыг нэвтрүүлж, Хромбүүк угсрах үйлдвэр байгуулах төслийг эхлүүлнэ.
Эрүүл мэндийн салбарт	Зүрх, судасны үндэсний төв, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-2 зэрэг эрүүл мэндийн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 17 аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл хэрэгжүүлж, Нийгмийн эрүүл мэндийн төв, дэд төв байгуулна.
Ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх хүрээнд	Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн орлогын түвшинд нийцсэн ипотекийн зээлийн төрөлжилтийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хүрээнд	Гадаад улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны чадавхыг бэхжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлнэ.
Гурав. Ногоон хөгжлийн чөлөөлөлт	Эрчим хүчний хараат байдлыг бууруулан, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр, айл өрхийн нарны хавтан зайн хураагуур, бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлж, ногоон дэд бүтцийг хөгжүүлэн, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шинэ боломжийг бий болгох, ногоон дата төв байгуулах, ногоон хөгжлийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.
Үндэсний үр дүн	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс 2025 онд 37.2 оноотой байгааг 2027 онд 40 оноонд хүргэж, орон нутгийн хөгжлийн индекс 0.506 байгааг 0.553-д хүргэнэ.
Сэргээгдэх эрчим хүчний салбарт	Нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлж, айл өрхийн нарны хавтан, бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлнэ.
Анхдагч экосистемийг хамгаалах чиглэлээр	Усны нөөцийг хуримтлуулж, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх "Хэрлэн-Тооно", "Онги-Цагаан бургастай" төслийн бэлэн байдлыг хангана. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн шинэчилсэн зорилтын хэрэгжилтийг хангаж, олон талын оролцоотой хамгааллын менежментийг хэрэгжүүлнэ.
Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр	"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд 10.0 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээж, Цөлжилт, газрын доройтлыг бууруулах суурин судалгааны төвийг байгуулж, ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтооно.
Дөрөв. Авлигын эсрэг чөлөөлөлт	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний хиймэл оюуныг хөгжүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж, цахим засаглал, ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлж, хариуцлагын механизмыг сайжруулан, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэн хууль давсан журмуудыг үе шаттайгаар бууруулж авлигын эсрэг чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.
Үндэсний үр дүн	Засаглалын үзүүлэлтээр 2025 онд 114 дүгээр байрт байгааг 2027 онд 7 байраар ахиулж, дэлхийн мэдлэгийн индекс 39.2 оноог 50 оноонд хүргэнэ.
Авлига, хүнд суртлыг бууруулах чиглэлээр	Авлигатай тэмцэх иргэний нийгэм, сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж, шүгэл үлээгчийг дэмжих мэдээллийн суваг, хамгаалалтыг сурталчлах, авлигын эсрэг соён гэгээрүүлэлт, хууль хэрэгжилтийн үнэлгээг хэрэгжүүлнэ.
Төрийн бүтээмж, засаглалын чиглэлээр	Төрийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгаж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюун нэвтрүүлж, Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулна.
Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр	Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөрийг өрсөлдөөнт хэлбэрээр нээлттэй хэрэгжүүлж, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулж, технологи дамжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
Дижитал эдийн засаг, хиймэл оюуны чиглэлээр	Хиймэл оюуны "Cloud GPU" дэд бүтцийг бий болгож, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх сэндрокс орчныг байгуулж, кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх системийг хөгжүүлнэ.